

Sight For All

Бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл болон дарамтаас хамгаалах бодлогын баримт бичиг



Sight For All нь бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл эсвэл аль ч төрлийн дарамтыг үл тэвчинэ. Sight For All-н төлөөлөгчид аливаа байгууллагатай хамтран ажиллахдаа харилцаа хандлага, ёс зүйн стандартыг дээд зэргээр баримтлан ажиллахыг эрмэлздэг. Sight For All-н эмзэг бүлгийн хүмүүсийг бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл болон дарамт шахалтаас сэргийлэх чиглэлийн үйл ажиллагааг идэвхтэй зохион байгуулдаг. For All байгууллагын Биеийн болон Бэлгийн хүчирхийллээс сэргийлэх хөтөлбөр нь бэлгийн мөлжлөг, хүчирхийллээс сэргийлэх, зүй бусаар нөлөөлөлд өртсөн хүмүүсийг хамгаалах болон дээрх чиглэлээр хэрэгжиж буй үйл ажиллагааны үр дүнгийн хяналтыг сайжруулах тухай тусгасан байна.

Sight For All-н PSEAH хөтөлбөр нь Sight For All-н бүх ажилтан, албан хаагч нарт хамаарах ба үүнд: Удирдах зөвлөлийн гишүүд, ажилтан албан хаагч нар, эрүүл мэндийн сайн дурын ажилтнууд (зохицуулагчид), эмнэлгийн бус сайн дурын ажилтнууд, нүдний эмч нар, хамтран ажиллагсад, төслийн оролцогчид, нүдний тасгийн эрхлэгч, гэрээт байгууллагууд, Sight For All төсөлд хамрагдсан орон нутгийн төлөөлөгчид болон Sight For All-тай албан ёсны гэрээтэй хамтран ажиллагч байгууллагууд орно.

Бодлого нь дараах зургаан үндсэн зарчмыг баримталдаг:

Зарчим 1: Хайхрамжгүй хандахыг үл тэвчих

Зарчим 2: Нийгэмд нөлөө бүхий манлайлагч нарын оролцоог нэмэгдүүлэх

Зарчим 3: Хохирогч/эмзэг бүлгийн хүмүүсийн асуудлыг нэн тэргүүнд тавих

Зарчим 4: PSEAH нь хүн бүхний хариуцлага

Зарчим 5: Хүйсийн тэгш бус байдал болон бусад эрх мэдлийн тэнцвэргүй байдлыг авч үзэх

Зарчим 6: Мэдээллийн ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх

Sight For All байгууллагын PSEAH хөтөлбөр нь дараах зорилготой:

- Бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, дарамтаас сэргийлэх зөвлөмжөөр хангах
- Бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, дарамтаас урьдчилан сэргийлэх эрсдэлийн менежментийн стратегиар хангах
- Sight For All-н ажилтнууд болон сайн дурын ажилтнуудыг шударга бус үйлдлээс хамгаалах
- Бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, дарамтыг сэжиглэж байгаа тохиолдолд юу хийх талаар тодорхой зааварчилгаа олгох

Үндсэн Тодорхойлолтууд

Бэлгийн мөлжлөг: Сул дорой байдал, эрх мэдлийн ялгаа, итгэлцлийг бэлгийн зорилгоор урвуулан ашиглах аливаа бодит үйлдэл эсвэл оролдлого. Үүнд бусдын бэлгийн мөлжлөгөөс санхүү, нийгэм, улс төрийн ашиг олох зэрэг орно.

Бэлгийн хүчирхийлэл: Бэлгийн шинж чанар бүхий хүч хэрэглэсэн, заналхийлсэн болон бие махбодод халдсан аливаа үйлдлийг хэлнэ. Үүнд: Хүчиндэх оролдлого (үүнд хэн нэгнийг аман секс хийхийг албадах оролдлого); болон бэлгийн хүчирхийлэл (үүнд харилцан зөвшилцөөгүй үнэсэлт, биед халдах. Насанд хүрээгүй хүнтэй үйлдсэн аливаа бэлгийн шинж чанар бүхий харьцааг бэлгийн хүчирхийлэл гэж үзнэ.

Бэлгийн дарамт: Бэлгийн хүчирхийллийн шинж чанар бүхий бие махбодын болон харилцааны, мэдээллийн хүчирхийлэл ба зохисгүй үг хэллэг бэлгийн шаардагагууд орно.

Бодлого Хэрэгжүүлэлт

Sight For All-н PSEAH хөтөлбөрт дараах үндсэн шаардлагууд тавигдана.

Ажилтан шалгаруулж авахад тавигдах шаардлага

Sight For All байгууллага нь ажилтан сонгон шалгаруулахдаа тухайн ажил албанд тохирох чадварж бүхий хүмүүсийг шалгаруулж авах бөгөөд хүүхэд залууст эрсдэл бүхий хүмүүсийг шууд болон шууд бусаар үйл ажиллагаанд оролцохуулахгүйг эрмэлзэнэ.

Сургалт

Sight For All-н бүх удирдах зөвлөлийн захирлууд, ажилтнууд, зохицуулагчид, сайн дурын ажилтнууд, нүдний эмч нар, хамтран ажиллагсад, төслийн оролцогчид, төслийн хамтрагчид, зөвлөхүүд болон гэрээт ажилчид нь PSEAH хөтөлбөрийн мэдээлэл болон эмзэг бүлгийн хүмүүстэй харилцах ёс зүйн дүрэмтэй танилцан гарын үсэг зурж баталгаажуулна. Сайн туршилгуудыг хэрэгжүүлэх, хөгжүүлэх сургалтад бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл болон бэлгийн дарамтаас сэргийлэх, хамгаалах үйл ажиллагааг цогцоор нь хэлэлцэхийг зорьсон.

Хамтын ажиллагаа

Sight For All -ийн хамтрагч төрийн бус байгууллагууд хүүхэд хамгааллын стандартыг баримтлан ажиллана.

Sight For All нь Засгийн газар болон хамтран ажиллагч байгууллагатай хүүхэд хамгааллын стандартыг хэрхэн мөрдөн ажиллах талаар түншлэлийн гэрээнд тусган хамтран ажиллана. Энэхүү стандарт мөрдөгдөөгүй алдаа, зөрчил гарсан тохиолдолд тухайн байгууллагатай хийсэн гэрээ цуцлахад хүрнэ.

Эрсдэлийн Менежмент

Бэлгийн мөлжлөг хүчирхийллээс сэргийлэх үйл ажиллагаа нь урт удаан хугацаа, хүчин чармайлт шаардсан ажил боловч Sight For All-н Бүх салбарт хүчирхийллийг багасгахыг эрмэлзэн ажиллаж байна. Sight For All-н үйл ажиллагаа бүрт эрсдэлийг тодорхойлж тохирсон менежмент хийж байна.

Бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, дарамтын эрсдлийг үнэлэх

Sight For All байгууллага нь бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, дарамтын эрсдэлийг үнэлэхэд зориулагдсан DFAT-н шийдвэр гаргах тогтолцоог дагаж мөрддөг. Гурван алхам байх ба үүнд:

- 1) Ажлын байрны бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, дарамтад өртөх эрсдэл бий юу?
Хэрэв тийм бол,
- 2) Эрсдэлийн төвшинг үнэлнэ
- 3) Бага/ дунд/ өндөр/ маш өндөр гэсэн эрсдэлийн төвшинд тохирсон үйл ажиллагааны стандартыг мөрдөн ажиллах

Эдгээр алхмуудын хэрэгжилтэд Sight For All үнэлгээ хийж хяналт тавин ажиллана.

Төслийн төвшинд эрсдэлийн үнэлгээг эхлэл үе шат болон үзэл баримтлалын үе шатуудад хийж, төслийн төлөвлөлт болон дизайны үе шатанд дахин үнэлдэг. Төслийн эрсдэлийн үнэлгээнд хамгаалал ба PSEAH эрсдэлүүд мөн болзошгүй эрсдэлийг бууруулах эсвэл арилгах арга хэмжээ болон зөвлөмжүүд багтдаг.

Мэдээлэх

Бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, дарамттай холбоотой бүх асуудал эсвэл мэдэгдлийг нэн даруй мэдээлэх ёстой. Sight For All нь бүх мэдээлсэн асуудалд нухацтай хандаж, нэн даруй арга хэмжээ авдаг.

Бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, дарамттай холбоотой асуудал эсвэл мэдэгдлийг шалгахдаа Sight For All нь шударга ёсны зарчмуудыг баримтлах болно. Sight For All-н Whistleblower бодлогод зааснаар аливаа асуудал болон мэдэгдэлд хатуу нууцлалтай хандах ба мэдүүлэг гаргагчийн нууцлал, илчлэгдсэн этгээдийн хэн болох, илчилсэн мэдээллийн агуулгыг нууцлах болно.

Sight For All-н PSEAH бодлого, DFAT PSEAH бодлогыг зөрчиж болзошгүй үйлдэл ажиглагдах эсвэл мөлжлөг, хүчирхийлэл, дарамттай холбоотой аливаа гомдол, мэдээллийг тухайн гэмт хэрэг, зөрчил гарснаас хойш ажлын хоёр өдрийн дотор мэдээлэх ёстой.

Зайлшгүй, нэн даруй мэдээлэх үүрэг

Sight For All дараах зүйлсийг мэдээлэхэд зориулсан тодорхой маягттай:

- Зайлшгүй, нэн даруй – тухайн хэрэг болсноос хойш ажлын 2 өдрийн дотор мэдээлнэ.
- Зайлшгүй - бодлого, доод стандарт эсвэл зарчмуудыг дагаж мөрдөөгүйг мэдсэнээс хойш ажлын 5 өдрийн дотор мэдээлнэ.

Хэрхэн мэдээлэх вэ?

Та дараах цахим хаяганд хандан мэдээлэл өгнө үү: <https://sightforall.org/complaints/> _

Доорхи хаягаар Sight For All-ийн суурин төлөөлөгчдөд хандана үү

Sight For All-ын Гүйцэтгэх Захирал – jhatswell@sightforall.org

Монгол/Шри-Ланка/Мьянмарын суурин төлөөлөгч – myanmarcountryofficer@sightforall.org

Камбожын суурин төлөөлөгч – cambodiacountryofficer@sightforall.org

Шри-Ланкын суурин төлөөлөгч – srilankacountryofficer@sightforall.org